



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 110/1

Бат-Өлзий сум

**Газар эзэмших эрх шинээр олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай” 136 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газар (9045651)-т Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, цогцолборын зориулалттай 5110м<sup>2</sup> газрыг 40 жилийн хугацаатай газар эзэмших эрх олгосугай.

2. Дээрх газар эзэмших эрх авсан байгууллагатай газар эзэмших эрхийн гэрээг зохих журмын дагуу байгуулан, эрхийн гэрчилгээ олгохыг газрын даамал (Э.Дэнсмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ

